



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 11 сарын 29 өдөр

Дугаар А/722

Ховд

Улсын комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар засварлагдсан Дөргөн сумын 3 худгийг хүлээн авах улсын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга: Б.Бямбажав - Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Гишүүд: Ц.Пүрэвсүрэн - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Х.Мөнхжаргал - Мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч

Б.Бямбажаргал - Байгаль орчин, аялал жуулчлалын газрын усны асуудал хариуцсан мэргэжилтэн

Б.Жамбалдорж - Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн

Х.Аманбол - Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн

Л.Цэдэн-Иш - Дөргөн сумын Засаг дарга

- Хариуцсан багийн Засаг дарга нар

Нарийн бичгийн

дарга: Э.Гансүх - Хүнс, хөдөө аж ахуйн газрын малын бэлчээр, тэжээл, усан хангамж хариуцсан мэргэжилтэн


2. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны санхүүжилтээр засварлагдсан “Инжинерийн хийцтэй гүний худаг” ажлыг холбогдох хууль тогтоомж, журам зааврын дагуу орон нутгийн өмчид хүлээн авч ажиллахыг ажлын хэсэгт даалгасугай.

2.

3. Дээрх хөрөнгийг орон нутгийн өмчид бүртгэж авахыг Дөргөн сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогчид даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга /Б.Бямбажав/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ